



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 451

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасч, бүртгэлд тусгах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хөрөнгөд бүртгэлтэй, Эрчим хүчний яамны барилгад хийгдсэн, 1,172,329,079.00 /нэг тэрбум нэг зуун далан хоёр сая гурван зуун хорин есөн мянга далан есөн/ төгрөгийн үнэлгээ бүхий их засварын хөрөнгийг тус компанийн бүртгэлээс хасч, Эрчим хүчний яамны барилга байгууламжийн дансанд капиталжуулан бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Диспетчерийн үндэсний төв” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Г.Балжинням нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийг данснаас хасч, үндсэн хөрөнгийн бүртгэлд тусгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ